



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/92

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “з”, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сум дундын отрын бүс нутгийг шинэчлэн тогтоох, бэлчээр ашиглалтын аймгийн журам боловсруулж, батлуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Н.Дулам (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)
С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Ц.Хашхүү (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)
Б.Цэнгэл (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга)
Л.Жаргалбаатар (аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны тэргүүн) (Зөвшилцсөнөөр)
Холбогдох сумын Засаг дарга нар
Нарийн бичгийн дарга:Т.Эрдэнэбаяр (аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

2.Отрын бүс нутгийг шинэчлэн тогтоох ажил болон бэлчээр ашиглалтын аймгийн журам боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөл болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүдэхийг Ажлын хэсэг (И.Доржсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100200

D:My Doc. Zahiramj. Zasag darga